



ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДААНЫ ТУХАЙ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА





Зэрлэг амьтны хууль бус худалдааны тухай иргэдэд зориулсан гарын авлага

Лондонгийн Амьтан Судлалын
Нийгэмлэгийн Монгол дахь
Төлөөлөгчийн газар

Улаанбаатар хот 2021 он

© Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг, 2021

Гарын авлага

Зэрлэг амьтны хууль бус худалдааны тухай иргэдэд зориулсан гарын авлага

2021 онд Улаанбаатар хотод хэвлэв.

Хуулбарлах тухайд

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгээс энэхүү гарын авлагыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжиж, хэсэгчлэн нийтлэх тухай зөвшөөрөл хүссэн тохиолдолд зохих зөвшөөрлийг даруй олгоно.

Эмхтгэсэн: Б. Мөнхжаргал

Хянан тохиолдуулсан: У. Тунгалаг

Гэрэл зураг: Д. Лхагвасүрэн

Хэвлэлийн эх, дизайн: Д. Лхагвасүрэн



Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн

Монгол дахь Төлөөлөгчийн газар,

Монре импекс ХХК-ийн байр, 302 тоот өрөө, Бага тойруу -47,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс. Утас: 77111138

АГУУЛГА

<u>Байгууллагын танилцуулга.....</u>	<u>4</u>
<u>Гарын авлагын зорилго.....</u>	<u>6</u>
<u>Яагаад бид зэрлэг амьтдыг хамгаалах ёстой вэ?.....</u>	<u>7</u>
<u>Зэрлэг амьтан ургамлын хууль бус худалдаатай тэмцэх ямар төрийн байгууллагууд байдаг вэ?.....</u>	<u>10</u>
<u>Цагдаагийн Ерөнхий Газар, Экологийн Цагдаагийн Алба ба орон нутаг дахь төлөөлөл.....</u>	<u>11</u>
<u>Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар ба орон нутаг дахь улсын байцаагч.....</u>	<u>12</u>
<u>Гаалийн Ерөнхий Газар ба хилийн боомтууд дахь гаалийн улсын байцаагч.....</u>	<u>14</u>
<u>Хил Хамгаалах Ерөнхий газар.....</u>	<u>16</u>
<u>Байгаль хамгаалагч.....</u>	<u>17</u>
<u>Гэмт хэрэг үү эсхүл зөрчил үү? Ямар ялгаатай вэ?.....</u>	<u>18</u>
<u>Гэмтхэрэг.....</u>	<u>18</u>
<u>Зөрчил.....</u>	<u>20</u>
<u>Гэмт үйлдэлд ноогдуулах хуулийн хариуцлага.....</u>	<u>22</u>
<u>Ан агнуур хаана хийж болохгүй вэ?.....</u>	<u>25</u>
<u>Та зэрлэг амьтан агнах хориотой хугацааг мэдэх үү?.....</u>	<u>27</u>
<u>Амьтан агнах хориотой арга хэрэгсэл гэж юу вэ?.....</u>	<u>30</u>
<u>Ямар амьтныг агнахыг хориглосон зэрлэг амьтад.....</u>	<u>31</u>
<u>Монгол улсын хуулиар хамгаалсан амьтад.....</u>	<u>32</u>
<u>Монгол Улс нэгдэн орсон САЙТИС-н конвенцийг яагаад бид мэдэх ёстой вэ?.....</u>	<u>35</u>
<u>Хуулийн хүрээнд агнуурын нөөцийг ашиглах вэ?.....</u>	<u>40</u>
<u>Монгол хүн та байгаль хамгаалахад ямар үүрэгтэй вэ?.....</u>	<u>43</u>
<u>Иргэний хувьд юу хийх вэ?.....</u>	<u>43</u>
<u>Мэдээлэл өгөх шугам юу вэ?.....</u>	<u>43</u>
<u>Зэрлэг амьтан ургамлыг хэрхэн таньж тодорхойлох вэ? - Гар утасны аппликейшн “Соргог”.....</u>	<u>44</u>

ЛОНДОНГИЙН АМЬТАН СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГИЙН ТУХАЙ ТОВЧ




© ZSL

4

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН) нь 1826 онд байгуулагдсан дэлхийн байгаль хамгааллын ууган байгууллагуудын нэг бөгөөд зэрлэг амьтан хамгаалах, шинжлэх ухааны судалгаа хийх, зэрлэг амьтны талаарх боловсролыг түгээх зорилготой. ЛАСН-т суут эрдэмтэн Чарльз Дарвин, орчин үеийн нөлөө бүхий байгаль хамгааллын зүтгэлтэн Сэр Дэвид Аттенборо нар ажиллаж байсан гэдгээрээ бахархдаг. Мөн Их Британи Улсын нийслэлд Лондонгийн болон Випснэйдийн хоёр алдартай амьтны хүрээлэнтэй. ЛАСН-ийн нэрийн хуудас болсон ажлууд бол зэрлэг амьтны хууль бус худалдааны

эсрэг тэмцэх, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн SMART байгаль орчны эргүүлийн (SMART patrolling tool) арга зүйг нэвтрүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент хийх, амьтны хүрээлэнгийн үйл ажиллагаагаар иргэдийг гэгээрүүлэх, байгаль хамгаалах чадавхыг сайжруулах юм. ЛАСН-ийн Азийн хөтөлбөрийн хүрээнд дэлхийд ховордож, устгах аюулд хүрээд буй Суматрын бар, хуягт нэхи (pangolin), Яавын хирс үхэр, хавтгай тэмээ, баданга хүдэр зэрэг амьтдыг хамгаалдаг.

ЛАСН нь Монгол Улсад үйл ажиллагаагаа 2003 оноос “Тал нутгийн түүчээ” хөтөлбөрөөр эхэлж, Байгаль Хамгаалах Олон Улсын Холбоо (БХОУХ *англ.* IUCN)-



ны шалгуураар Монгол орны загас, шувуу, хоёр нутагтан, мөлхөгч, хөхтөн амьтны болон ургамлын үнэлгээг хийж Улаан дансыг боловсруулан гаргасан нь Азид анхны ажил болсон. Монгол орны хөхтөний хээрийн ажлын аргачлал, Монгол Улсын Биологийн олон янз байдлын үндэсний 5 дугаар тайлан, Зэрлэг амьтны зурган индекс, “Зэлүүд тал-2” зэрлэг амьтны хууль бус худалдааны талаарх судалгааны тайлан, зэрлэг амьтан ургамал таних “Соргог” аппликэшн зэрэг нэлээд хэдэн бүтээл гаргаад байна. Өнөөгийн байдлаар ЛАСН-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар нь зэрлэг амьтны хууль бус худалдааг таслан зогсоох, нутгийн иргэдтэй хамтран орон нутгийн тусгай хамгаалалттай газрын

менежментийн загвар буй болгож баданга хүдэр, талын бүргэд, идлэг шонхор, тарвага хамгаалах, Говийн их дархан цаазат газарт хавтгай тэмээний нүүдлийн судалгаа хийх, орчны бүсийн менежментээр тус зүйлийг хамгаалах чиглэлээр гурван төсөл хэрэгжүүлж байна.

ЛАСН-ийн Байгаль хамгааллын хөтөлбөрийн хүрээнд Ази, Африк, Европ тивээр тархсан хуурай газар, цэнгэг усны болоод далайн биологийн олон янз байдал, ялангуяа ховор, нэн ховор зүйлүүд, тэдгээрийн идээшил нутгийг судлах, талуудын оролцоотой хамгаалах, нутгийн иргэдийг байгаль хамгаалах ажилд татан оролцуулах ажлыг 50 гаруй оронд хэрэгжиж буй төслүүдээрээ дамжуулан гүйцэтгэдэг.

ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛГО

Энэхүү гарын авлагын зорилго бол иргэдийн зэрлэг амьтны хууль бус худалдааны талаарх мэдлэг ойлголтыг сайжруулахуйц мэдээлэл өгөх, улмаар хүмүүс гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, байгаль орчиндоо эерэг хандах суурь мэдлэгийг нь тэлэх явдал юм. Гарын авлагад зэрлэг амьтдын худалдааны өнөөгийн

нөхцөл байдлын талаар товч мэдээлэл, зэрлэг амьтны агнуур, худалдаанд хяналт тавьдаг төрийн байгууллагуудын эрх, үүрэг, хууль бус гэмт хэрэг, зөрчилд хамаарах үйлдлийн тухай танилцуулга, амьтан агнах хориотой хугацаа, газар болон агнаж худалдаалахыг хориглосон амьтдын талаарх мэдээллийг багтаасан болно.



© ZSL

ЯАГААД БИД ЗЭРЛЭГ АМЬТДЫГ ХАМГААЛАХ ЁСТОЙ ВЭ?



© ZSL

Монгол орны зэрлэг амьтны хууль бус худалдааны гол хөтлөгч хүчин зүйлүүд нь олон улсын худалдаа тэр дундаа БНХАУ-ын зэрлэг амьтны гаралтай түүхий эд, ургамлын асар их эрэлт хэрэгцээнээс үүдэн Монгол Улс амьтны гаралтай хууль бус барааг хятадын зах зээлд дамжуулагч болсон явдал, Монголчууд өөрсдөө харь ховор зэрлэг амьтны төрөл зүйлийг хэрэглэгч болсон, манай хууль хяналтын байгууллагуудын хүчин чадал дутмаг, өргөн уудам нутаг дэвсгэрт үр дүнтэй хяналт тавих нь бэрхшээлтэй, гэмт хэрэг нарийн зохион байгуулалттай сүлжээ болж буй зэрэг юм.



© Financial Times

Эдгээр шалтгааны улмаас манай орны зарим амьтад хэрхэн “хэлмэгдэж” тоо толгой нь буурч байгааг “Зэлүүд тал-2” судалгаа тодорхой үзүүлсэн.

Монгол бөхөн: тоо толгой нь 5,000 байснаас 800 хүрэхгүй буюу

1996-2015		
МОНГОЛ УЛС ЭКСПОРТОЛСОН ЗЭРЛЭГ АМЬТНЫ ТОО ХЭМЖЭЭ		
Хамгийн олон 10 төрөл зүйл		
#	Төрөл зүйлс	Зөвшөөрөл
#1	Идлэг шонхор	24,873
#2	Хүрэн баавгай	3,402 ¹
#3	Соорал чоно	2,708
#4	Аргаль	2,369
#5	Хонин тоодог	1,912
#6	Цармын бүргэд	1,529
#7	Хулсан	980
#8	Ирвэс	664
#9	Мануул	527
#10	Баданги хүдэр	309
	Бусад	2,098
		41,371
* Дараах зүйлсийг хамруулсан (амьд зүйл, үс, дээж, гавал, трофи агнуур, дагавар бүтээгдэхүүн гэх мэт.)		


“Нэн ховор” зүйлүүд бол Монгол бөхөн (нэн ховор), цоохор ирвэс (нэн ховор), халиун буга (ховор) болон хүрэн баавгай (ховор) юм.

Байгаль экосистемд ач холбогдол бүхий эдгээр амьтдыг судалгаагүйгээр хэт их агнаж ашиглах нь экологийн тэнцлийг алдагдуулж, улмаар байгалийн хишгээр амьдардаг хүмүүний амьдралд асар их сөрөг нөлөөтэй. Өвсөн тэжээлтэн амьтад ургамлын үрийг тараан түгээж бэлчээрийн шимт ургамал ургахад чухал үүрэгтэйгээс гадна махчин амьтдын идэш тэжээл болж байдаг.

Хүний амьдралын чанар байгалийн өгөөж хишиг буянаас шууд хамааралтайг бидний өвөг дээдэс эрт дээр үеэс гүнзгий ойлгож, байгалиа хайрлаж гамнасан олон ёс

8

85% буурсан (Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, 2004). Халиун буга: тоо толгой 1986 онд 130,000 байснаас 2004 онд 8,000-10,000 болж, харин 18 жилийн дараа гэхэд 92%-иар буурчээ. 1985 онд нийт 60,000-аар тоологдож байсан аргаль 2001 онд 13,000-15,000 болж тоологдсон (Амгаланбаатар болон бусад, 2002) нь 16 жилийн хугацаанд 75% буурсан үзүүлэлт юм. Нэгэн үе 40 сая байсан тарвага 2002 он гэхэд 5 сая болсон нь 12 жилийн дотор 75%-иар буурсан (Батболд, 2002). 1999 онд 3,000 хос хэмээн үзэж байсан идлэг шонхор 2004 онд 2,200 болсон нь 5 жилийн дотор 30% буурсан үзүүлэлт байна (Шагдарсүрэн 2001). Янгир ямаа, Монгол цагаан зээр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, аргаль болон чоно нь анчдын хамгийн их агнадаг амьтад болжээ. Эдгээрээс маш их худалдаалагдаж буй “Ховор” болон





Экосистемийн үйлчилгээний хүний амьдралын сайн сайханд үзүүлэх нөлөө

заншил, дэг жаягтай байсан.

Өвгөдийн ухааныг 21 дүгээр зууны эхэнд дэлхийн эрдэмтэд батлан харуулж хүний амьдралын сайн сайхан нь байгаль, экосистемийн үйлчилгээнээс ямар их нарийн хамааралтайг тодорхойлсон байдаг (МЕА, 2005). Сайхан аз жаргалтай амьдрал гэдэг бол айх аюулгүй байж, амьдралаа тэтгэх наад захын материаллаг үндэс суурьтай, эрүүл чийрэг, эв найртай нийгмийн уур амьсгал, харилцаанд байх гэсэн дөрвөн үндсэн зүйлээс хамаарч хүн бүр өөрийн үнэт зүйлсийн төлөө амьдарч, хүсэл мөрөөдлөө биелүүлэх сонголтоо хийх эрх чөлөөтэй байхыг хэлдэг ажээ. Хүний

аз жаргалтай амьдралыг бүтээхэд байгалиас дэмжих үйлчилгээ үзүүлж шаардлагатай нөөцөөр хангах, амьдрах орчныг зохицуулах болон зан заншил соёлоороо өөрийгөө тодорхойлох боломж бүрдүүлж тэтгэж байдаг. Ийм учраас монгол хүн бүр хангайн сайхан амьтдыг харж нутаг усаараа бахархах хайрлах, сүсэглэх зэрэг сайхан мэдрэмж авч байдаг нь тэрхүү өөрийгөө тодорхойлох соёлын зан заншлын нэг хэсэг билээ. Эдгээр үнэт зүйлгүй болбол бид амьдралаа тэтгэх байгалийн хишиг буяныг алдахаас гадна монгол гэж өөрсдийгөө тодорхойлох зүйлгүй болох юм.

ЗЭРЛЭГ АМЬТАН УРГАМЛЫН ХУУЛЬ БУС ХУДАЛДААТАЙ ТЭМЦДЭГ ЯМАР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД БАЙДАГ ВЭ?



10

Монгол Улсад хууль тогтоох засаглалын байгууллагаас эхлээд гүйцэтгэх засаглалын нийт 8 байгууллага (орон нутгийн засаг захиргааг оруулан тооцоход) өөрсдийн чиг үүргийн дагуу ажиллахаас гадна шүүх засаглалын харьяа улсын прокурор, шүүх хамтран зэрлэг амьтны хууль бус

худалдаатай холбоотой зохицуулах, удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (МХЕГ), Гаалийн Ерөнхий Газар (ГЕГ), Тагнуулын Ерөнхий Газар (ТЕГ), Хил Хамгаалах Ерөнхий Газар (ХХЕГ) зэрэг хууль сахиулах үүрэг бүхий байгууллагууд нь тодорхой түвшинд хяналт шалгалтын арга хэмжээ авч ажилладаг.



Цагдаагийн
Ерөнхий Газар,
Экологийн
Цагдаагийн
Алба, түүний
орон нутаг дахь
төлөөлөл

Эдгээр нь зэрлэг амьтны гаралтай хууль бус бүтээгдэхүүн илрүүлж, цаашид мөрдөн байцаах шаардлага үүссэн үед тухайн сэжигтэй тохиолдлыг цагдаагийн байгууллагын албан ёсны мөрдөн байцаалтад шилжүүлэх үүрэгтэй байдаг. Цагдаагийн байгууллага нь хууль бус агнуур, худалдааны мөрдөн байцаах, шаардлагатай баримт нотолгоог тогтоохын тулд Шинжлэх Ухааны Академийн Биологийн хүрээлэн, мөн хууль бус үйлдлийг шүүхийн шатанд шийдүүлэхийн тулд прокурорын байгууллагатай хамтран ажилладаг. 2020 онд Экологийн Цагдаагийн Алба шинээр байгуулагдаж 21 аймаг 64 суманд экологийн асуудал хариуцсан алба хаагчтай ажиллаж байна. Энэ алба нь хүрээлэн буй орчны эсрэг гэмт

хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.



© Д. Лхагвасүрэн



Мэргэжлийн
Хяналтын
Ерөнхий Газар,
түүний орон
нутаг дахь
улсын байцаагч

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар нь олон салбарын үйл ажиллагаанд хяналт хийдэг бөгөөд зэрлэг амьтны агнуур, худалдааны хяналт шалгалтыг аймаг, сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчидтай хамтран гүйцэтгэдэг. Байгаль орчны байцаагч, дотоодын ан агнуур, загасчлал, зэрлэг амьтан хууль бусаар тээвэрлэх болон худалдаалах үйл ажиллагааг хянан удирддаг. Улсын боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын алба нь зэрлэг амьтан ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцын (САЙТИС *англ.* CITES) зөвшөөрөл, худалдааны асуудлаар гаалийн байгууллагатай хамтран ажилладаг. Тус албаны байцаагчид хилийн боомт дээр байрлан ажиллаж, гаалийн албан

хаагчид анхдагч үзлэг хийсний дараа худалдаалж буй бараа, бүтээгдэхүүн нь хууль ёсны эсэхийг баталгаажуулдаг. Өөрөөр хэлбэл, хилийн мэргэжлийн хяналтын байцаагчид тухайн зөвшөөрөл нь хууль ёсны эсэх, худалдаалж буй зүйлийн тоо хэмжээ нь олгосон зөвшөөрөлтэй нийцэж буй эсэхийг батлах замаар хоёр дахь шалгалтыг хилийн бүсэд хийдэг.

Аймгийн түвшинд улсын ахлах байцаагч болон улсын байцаагч нар хэрэгжүүлэх эрхийн хүрээнд хууль бус үйл ажиллагааг саатуулах, зогсоох, иргэний баримт бичгийг шалгах, авто тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хураан авч саатуулах, мөн хууль бус эд хөрөнгө, зэвсэг, тоног төхөөрөмж, багаж зэргийг хураан авах үүрэгтэй. Мөн барилга байгууламж хураан авах эрхтэй бөгөөд энэ нь тухайн шатны улсын

МОНГОЛ - ХЯНАХ ШААРДЛАГАТАЙ ӨРГӨН УУДАМ НУТАГ



1,56 сая км²
газар нутаг




10,409 км гол мөрөн
13,418 км² нуур



120 Тусгай хамгаалалттай
газар нутаг
Улсын газар
нутгийн **21%**

8,252

км урт олон улсын хил



байцаагч нарт олгогдсон өвөрмөц эрхбайдаг. Байцаагчдын гүйцэтгэдэг хяналт, шалгалтын ажлын хувьд тэдний эдлэх эрх нь аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрэх эрхтэй ч хувийн орон сууц, гэрт саадгүй нэвтрэх боломжгүй. Нөгөө талаар, байцаагчид бусдыг саатуулах эрхтэй хэдий ч мөрдөн байцаалт явуулах эрхгүй. Сумын байгаль хамгаалагч нь хууль тогтоомж хэрэгжүүлэх тодорхой эрх бүхий дараагийн шатны албан хаагч юм. Байгаль хамгаалагчид нь сумын түвшинд ажиллаж, зэрлэг амьтны хууль бус агнуур, худалдаатай тэмцэх эргүүл, хяналтын арга хэмжээг гүйцэтгэдэг.



© Д. Лхагвасүрэн



Гаалийн
Ерөнхий
Газар ба хилийн
боомтууд дахь
гаалийн улсын
байцаагч

Гаалийн Ерөнхий Газрын ажилтнууд Монгол Улсын хилээр хориглосон болон хязгаарласан бараа нэвтрүүлэлтийг хянах, олон улсын зэрлэг амьтан ургамлын худалдааны журмыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй. Тэд хилийн бүсэд хяналт хийж, зөвшөөрлийг шалган тээвэрлэлтийн баримт бичиг, авто тээврийн хэрэгслийн бүртгэл зэргийг нягталж, худалдааны хууль ёсны байдлыг шалгах зорилгоор бараа, бүтээгдэхүүнд үзлэг хийдэг. Ийнхүү анхан шатны үзлэг хийхдээ тухайн бараа, бүтээгдэхүүний мэдүүлэг нь хууль ёсны эсэхийг тодорхойлно. Хэрэв хууль ёсны бараа бол МХЕГ-ын байцаагч нь

тухайн барааны стандарт, чанар, гэрчилгээ, зөвшөөрлийг (САЙТИС-ын экспорт, импортын зөвшөөрөл) шалгадаг. Гаалийн байцаагч нь тухайн барааг хууль бус хэмээн үзэж сэжиглэсэн бол тухайн асуудлыг цагдаад шилжүүлнэ. Захиргааны хариуцлага ноогдуулах торгууль болон зөрчлийн хэмжээнээс хэтрэх тохиолдолд уг хэргийг тухайн гаалийн боомтод ажиллаж буй цагдаагийн ажилтанд шилжүүлдэг. Тээврийн хэрэгсэлд мөн бараа, бүтээгдэхүүн хийж нууцаар хил нэвтрүүлж буй эсэхэд шалгалт хийнэ. Тухайн бараа, баримт бичиг эсвэл үйлдэл нь сэжигтэй бол тухайн асуудлыг мэргэжлийн хяналтын албаны мэдэлд шилжүүлнэ.



Хил Хамгаалах Ерөнхий Газар нь Монгол Улсын 8,252 км урт хилийн бүсийг, 15 км өргөн хилийн зурвасын хамтаар хамгаалан, хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй ба хамрах нийт газар нутгийн хэмжээ нь 123,780 км хүрнэ. Тус байгууллагын үндсэн зорилго нь алан хядагчид болон тухайн үйл ажиллагаанд ашиглаж болох зэвсэг, хэрэгсэл хил нэвтрэн орж ирэхээс сэргийлэхэд оршино. Мөн хил зөрчигч, хууль бус цагаач иргэд орж ирэхээс хамгаалах, бараа эд зүйлсийг хууль бусаар хил дамнуулан худалдахаас сэргийлнэ. Тус газар нь хил нэвтрэх боомтууд дээр нийт 46 шалган нэвтрүүлэх

цэгтэй бөгөөд олон улсын 14 боомт, хоёр улсын иргэд нэвтэрдэг хилийн 14 түр боомт, хоёр талын 10 боомт, 7 транзит боомт дээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр албад нь хил нэвтрэх баримт бичиг шалган нэвтрүүлэх үндсэн үүрэгтэй боловч ХХЕГ-ын ажилтнууд нь гааль, цагаачлал, хөдөө аж ахуйн чиглэлийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэггүй. Үндэсний аюулгүй байдал, хил хамгаалах чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахаас гадна тус байгууллага нь холбогдох хууль сахиулах бусад байгууллагуудад сэжигтэй тохиолдлуудыг шилжүүлж хамтран ажиллана.



Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн байгаль хамгаалагч нь нэгжлэг хийх, эд зүйлс хураан авах эрхийг зөрчил гарсан газар дээр хэрэгжүүлдэг. “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулийн хүрээнд тусгай хамгаалалттай газруудад ажилладаг байгаль хамгаалагч нар ийм эрхтэй. Тэд Дархан цаазтай газар болон Байгалийн цогцолбор газарт буй зэрлэг амьтныг хамгаалж, тэдгээрийг хууль бус худалдаанд өртөхөөс урьдчилан сэргийлж ажилладаг. Эдгээр байгаль хамгаалагчид нь байгаль орчны улсын байцаагчтай ижил статустай,

“Амьтны тухай” хуулийн дагуу хууль бус үйл ажиллагааг саатуулах, зогсоох, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хууль бус эд хөрөнгө, зэвсэг, хэрэгслийг хураан авах эрхтэй. Сумын байгаль хамгаалагч нь ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гарал үүслийн тодорхойлолт олгох эрхтэй. Өөрийн сумын хэмжээнд байгаль орчныг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлийн мэдээллийг иргэдэд өгөх, зөрчлийн талаарх мэдээллийг байцаагч, цагдаа зэрэг хууль сахиулах ажилтанд өгч хамтран ажиллана.

ГЭМТ ХЭРЭГ БА ЗӨРЧИЛ ЯМАР ЯЛГААТАЙ ВЭ?



Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан үйлдэл эс үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх бөгөөд “Зөрчлийн тухай” хуулиар зохицуулсан үйлдэл эс үйлдэхүй нь зөрчил юм. Дээрх зурагт зэрлэг амьтан агнах, худалдаалахтай хамаатай хууль тогтоомжуудыг дэс дарааллаар нь байрлуулсан ба тэдгээрийн төвд Үндсэн хууль байдгийг харуулжээ. Энэ зурагт манай улсын хуулиуд

зэрлэг амьтны агнуур, худалдаа, хууль хэрэгжилтийн чиглэлээр хэрхэн хуваагддаг болохыг үзүүлжээ.

Гэмт хэрэг

Зэрлэг амьтны эсрэг гэмт хэргийн үйлдэл, ийм гэмт хэрэгт ноогдуулах хариуцлагын талаар энэ хэсэгт тайлбарлах болно. Эрүүгийн хуульд амьтантай хамаарал бүхий томоохон гэмт хэргийг эрүүгийн хуульд



хамруулж, зохион байгуулалттай гэмт хэрэг, аж ахуйн нэгжийн эрүүгийн хариуцлагыг шинээр оруулж, үг хэллэгийг хоёрдмол утгагүй тодорхой болгожээ.

Хууль бусаар ан агнахтай холбоотой доорх үйлдлүүдийг гэмт хэрэг хэмээн эрх зүйн актууд тодорхойлдог:

1. Амьтныг тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр агнах (Эрүүгийн хуулийн 24.5.1)
2. Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнах (Эрүүгийн хуулийн 24.5.1)
3. Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнах (Эрүүгийн хуулийн 24.5.2)
4. Амьтныг тусгай хамгаалалттай газарт зөвшөөрөлгүйгээр барих (Эрүүгийн хуулийн 24.5.1)
5. Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр барих (Эрүүгийн хуулийн 24.5.1)
6. Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр барих (Эрүүгийн хуулийн 24.5.2) гэмт хэрэг юм.
Хууль бус худалдааны сүлжээний



гэмт хэрэгт дараах үйлдлүүдийг тооцно:

1. Ховор амьтны гаралтай түүхий эдийг тусгай зөвшөөрөлгүйгээр бэлтгэх (Эрүүгийн хуулийн 24.5.1)
2. Нэн ховор амьтны гаралтай түүхий эдийг тусгай зөвшөөрөлгүйгээр бэлтгэх (Эрүүгийн хуулийн 24.5.2)
3. Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр тээвэрлэх (Эрүүгийн хуулийн 24.5.1)
4. Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр тээвэрлэх (Эрүүгийн хуулийн 24.5.2)
5. Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр хадгалах (Эрүүгийн хуулийн 24.5.1)
6. Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр хадгалах (Эрүүгийн хуулийн 24.5.2)
7. Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр худалдаалах (Эрүүгийн хуулийн 24.5.1)
8. Нэн ховор амьтныг тусгай

зөвшөөрөлгүйгээр худалдаалах
(Эрүүгийн хуулийн 24.5.2)

9. Ховор амьтныг тусгай
зөвшөөрөлгүйгээр худалдан авах
(Эрүүгийн хуулийн 24.5.1)

10. Нэн ховор амьтныг тусгай
зөвшөөрөлгүйгээр худалдан авах
(Эрүүгийн хуулийн 24.5.2)

11. Ховор амьтныг тусгай
зөвшөөрөлгүйгээр экспортлох
(Эрүүгийн хуулийн 24.5.1)

12. Нэн ховор амьтныг тусгай
зөвшөөрөлгүйгээр экспортлох
(Эрүүгийн хуулийн 24.5.2)

13. Хориглосон, хязгаарласан
бүтээгдэхүүнийг хууль бусаар
хил давуулах (Эрүүгийн хуулийн
18.5.1)

14. Ховор амьтны трофи,
түүхий эд эрхтэн ба түүнээс
гаралтай бүтээгдэхүүнийг тусгай
зөвшөөрөлгүйгээр цуглуулах
(Эрүүгийн хуулийн 24.5.1)

15. Нэн ховор амьтны трофи,

түүхий эд эрхтэн ба түүнээс
гаралтай бүтээгдэхүүнийг тусгай
зөвшөөрөлгүйгээр цуглуулах
(Эрүүгийн хуулийн 24.5.2)

Зөрчил

“Зөрчлийн тухай” хуулийг 2015 онд шинэчлэн найруулсан. Энэ хууль нь өмнө нь 220 гаруй хуулиар зохицуулж байсан захиргааны олон төрлийн зөрчил, хариуцлагыг нэгтгэх зорилготой. Тус хуулийн нэг бүлэг нь байгаль орчны тухай хуулийн эсрэг зөрчлүүд, мөн “Амьтны тухай” хууль, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хууль, “Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдах тухай” хууль зэрэг хуульд хамаарах зөрчлүүдийг тусгажээ.

Зэрлэг амьтныг хууль бусаар агнахтай холбоотой дараах гэмт үйлдлүүдийг зөрчил хэмээн Зөрчлийн хуульд заажээ:

1. Зөвшөөрөлгүйгээр амьтныг агнах (Зөрчлийн тухай хууль 7.6.1)
2. Гэрээгүйгээр амьтныг үйлдвэрлэлийн зориулалтаар агнах (Зөрчлийн тухай хууль 7.6.1)
3. Хугацаа дууссан гэрээгээр амьтныг агнах (Зөрчлийн тухай хууль 7.6.1)
4. Амьтныг агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлэх (Зөрчлийн тухай хууль 7.6.2)
5. Ан агнах гэрээг бусдад шилжүүлэх (Зөрчлийн тухай хууль 7.6.2)
6. Ан агнах тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх (Зөрчлийн тухай хууль 7.6.2)





7. Ан агнах эрхийн бичгийг бусдад шилжүүлэх (Зөрчлийн тухай хууль 7.6.3)
8. Монгол Улсын хилийн бүсэд мөрдөгдөх ангийн холбогдолтой



- журмыг зөрчих (Зөрчлийн тухай хууль 16.1.1.1)
9. Агнуурын бүс нутгаас бусад газарт агнах (Зөрчлийн тухай хууль 7.6.4)
 10. Амьтныг агнах хориотой улиралд агнах (Зөрчлийн тухай хууль 7.6.4)
 11. Амьтныг бусад хориотой үед агнах (Зөрчлийн тухай хууль 7.6.4)
 12. Хориглосон арга хэрэгслээр агнах (Зөрчлийн тухай хууль 7.6.4)
 13. Гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн агнах (Зөрчлийн тухай хууль 7.6.3)
 14. Амьтныг зөвшөөрөлгүйгээр барих (Зөрчлийн тухай хууль

7.6.1.2)

15. Хугацаа дууссан зөвшөөрөлтэйгөөр амьтныг барих (Зөрчлийн тухай хууль 7.6.1)
16. Гэрээгүйгээр амьтныг үйлдвэрлэлийн зориулалтаар барих (Зөрчлийн тухай хууль 7.6.1.2)
17. Гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлсэн байх (Зөрчлийн тухай



- хууль 7.6.3)
18. Загасчлах гэрээг бусдад шилжүүлэх (Зөрчлийн тухай хууль 7.6.2)
 19. Загасчлах тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх (Зөрчлийн тухай хууль 7.6.2)
 20. Загасчлах эрхийн бичгийг бусдад шилжүүлэх (Зөрчлийн тухай хууль 7.6.2)

- Зэрлэг амьтныг хууль бусаар худалдаалахтай холбоотой дараах зөрчлүүдийг хуульд тодорхойлжээ:
1. Амьтантай холбоотой хуулиар хориглосон зар сурталчилгаа захиалах (Зөрчлийн тухай хуулийн 10.1)
 2. Амьтантай холбоотой хуулиар хориглосон зар сурталчилгаа хийх (Зөрчлийн тухай хуулийн 10.1)



3. Амьтантай холбоотой хуулиар хориглосон зар сурталчилгааг түгээх (Зөрчлийн тухай хуулийн 10.1)
4. Зэрлэг амьтан ба тэдгээрийн гаралтай эд эрхтнийг тусгай зөвшөөрөлгүйгээр худалдаалах (Зөрчлийн тухай хууль 7.6.5)
5. Зэрлэг амьтан ба тэдгээрийн гаралтай эд эрхтнийг гарал үүслийн гэрчилгээгүйгээр худалдаалах (Зөрчлийн тухай хууль 7.6.5)
6. Тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичиггүйгээр зэрлэг амьтан ба тэдгээрийн гаралтай эд эрхтнийг худалдан авах (Зөрчлийн тухай хууль 7.6.5)
7. Харь зүйлийг зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад нутагшуулах (Зөрчлийн тухай хууль 7.6.7)

8. Зэрлэг амьтан ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцоор хамгаалсан зүйл амьтныг (ховор эсхүл нэн ховор амьтны жагсаалтад багтаагүй) авч хууль бусаар хил давуулах (Зөрчлийн тухай хууль 7.3)
9. Зэрлэг амьтныг зөвшөөрөлгүйгээр ашиглах (Зөрчлийн тухай хууль 7.6.1)
10. Зэрлэг амьтныг хугацаа дууссан зөвшөөрөлтэйгөөр ашиглах (Зөрчлийн тухай хууль 7.6.1)

Гэмт үйлдэлд хүлээх хуулийн хариуцлага

Зэрлэг амьтны хууль бус агнуур худалдаатай холбоотой хэд хэдэн үйлдэлд Монгол Улсын хуулиар зөрчлийн болон эрүүгийн хариуцлага хүлээнэ. “Ховор”, “нэн ховор” жагсаалтад багтсан зэрлэг амьтанд хамаатай хууль бус үйлдэл нь эрүүгийн хуулиар, харин бусад



зүйлийн хувьд торгуулийн шийтгэл хүлээнэ.

Ховор амьтны жагсаалтад орсон амьтныг агнасан, барьсан, түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, экспортолсон, түүхийг эдийг цуглуулсан бол доод хэмжээ нь 5,400 нэгжээр, дээд хэмжээ нь

27,000 нэгжээр торгоно. (5.4 сая-27 сая төгрөг). Ижил төрлийн гэмт хэрэгт ноогдуулах шийтгэл нь 1-5 жилийн хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсвэл 1-5 жил хорих ял ноогдуулахаар заасан байна (Эрүүгийн тухай хууль 24.5.1).

Нэн ховор амьтныг агнах, барих, тусгай зөвшөөрөлгүй бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, худалдан авах, экспортлох, цуглуулах гэмт хэргийн хувьд хамгийн багадаа 10,000 нэгжээр, ихдээ 40,000 нэгжээр торгох ба энэ нь 10 сая - 40 сая төгрөгтэй тэнцэнэ. Эрүүгийн гэмт хэрэг хэмээн үзэх бол энэхүү үйлдэлд 2-8 жил хүртэл хугацаагаар



хорих ял ноогдуулна (Эрүүгийн тухай хууль 24.5.2).

Ховор ба нэн ховор амьтнаас бусад амьтны зүйлүүдтэй холбогдох гэмт үйлдлүүдийг зөрчил гэдгийг өмнө хэсэгт тодорхойлсон бөгөөд ноогдох шийтгэл нь торгууль юм. Дахин зөрчлийг гаргуулахгүйн тулд багахан торгууль ноогдуулж байсан өмнөх хуулийг бодвол шинэ “Зөрчлийн тухай” хуульд торгуулийн хэмжээг нэмсэн юм.


Зэрлэг амьтныг хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан бол

зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг нь хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр (150,000 төгрөг) торгоно (Зөрчлийн тухай хууль 7.6.1).

Зэрлэг амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 150 нэгжтэй тэнцэх (150,000 төгрөг) хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 1500 нэгжтэй тэнцэх (1,500,000 төгрөг) хэмжээний төгрөгөөр торгоно (Зөрчлийн тухай хууль 7.6.2).

Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 300 нэгжтэй тэнцэх (300,000 төгрөг) хэмжээний төгрөгөөр торгоно (Зөрчлийн тухай хууль 7.6.3).

Агнуурын бүснүтгаас бусад газарт,



эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 300 нэгжтэй тэнцэх (300,000 төгрөг) хэмжээний төгрөгөөр торгоно (Зөрчлийн тухай хууль 7.6.4).

Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 300 нэгжтэй тэнцэх (300,000 төгрөг) хэмжээний төгрөгөөр торгоно (Зөрчлийн тухай хууль 7.6.5).

Зэрлэг амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 500 нэгжтэй тэнцэх (500,000 төгрөг) хэмжээний төгрөгөөр торгоно (Зөрчлийн тухай хууль 7.6.6).

Харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 1000 нэгжтэй тэнцэх (1,000,000 төгрөг) хэмжээний төгрөгөөр торгоно (Зөрчлийн тухай хууль 7.6.7).

Ховор, нэн ховор амьтнаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай

түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 300 нэгжтэй тэнцэх (300,000 төгрөг) хэмжээний төгрөгөөр торгоно (Зөрчлийн тухай хууль 7.6.8).



АН АГНУУР ХААНА ХИЙЖ БОЛОХГҮЙ ВЭ?

Зэрлэг амьтны агнуур, худалдааг зохицуулахад газар нутаг, байршил чухал тэдгээрийг агнах болон худалдаалах үйл явц нь тухайн амьтны тоо толгойн байдлаас үл хамааран агнуурын бүс нутагт хийгдэнэ. Монгол Улс нь тухайн газар, орон нутагт тохируулсан агнуур зохион байгуулах аргачлалыг ашиглан зэрлэг амьтны менежментийн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Жишээлбэл, Монгол Улсын бүх тусгай хамгаалалттай газар нутагт

агнуур хийх хориотой. Зөвхөн нэг л байгалийн цогцолборт газар хувийн хэрэгцээнд зориулан загас барихыг зөвшөөрдөг. “Амьтны тухай” хуульд газар нутагт суурилсан хэд хэдэн аргачлалыг оруулсан. Үүнд тусгайлан заасан ангийн бүс тогтоох; ангийн түр хориог тодорхой газруудад тавих; орон нутаг өөрийн нутаг дэвсгэрт агнуурыг хориглох; түүнчлэн ангийн бүс нутагт зэрлэг амьтны үнэлгээ хийх, тоо хэмжээг тогтоох зэрэг багтаж байна. Аймаг, сумын засаг захиргаа нь Монгол Улсын нутаг дэвсгэрт загас болон бусад зэрлэг амьтны агнуурын нөөцийг зохицуулахад оролцдог

чухалталуудын нэг юм. Орон нутгийн захиргаад хуулиар олгогдсон эрхийн хүрээнд зэрлэг амьтны тоо толгойн судалгаа хийх, зэрлэг амьтан хамгаалах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ)-тай хамтран ажиллах, мөн “Амьтны тухай” хуулийн хэрэгжилтийг хангах (тоо хэмжээ болон хоригийн тухайд) зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Монгол Улсын хэмжээнд нийт 69 агнуурын бүсийг тогтоосон батдгээрийн удирдлага,

хяналт нь орон нутгийн түвшинд хэрэгждэг. “Амьтны тухай” хуульд зааснаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь агнуурын амьтны тархац нутагт амьтныг агнах, барих агнуурын бүс нутгийг ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд үндэслэн тогтооно. Тус хуульд зааснаар агнуурын бүс нутаг гэж “агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутгийг хэлнэ” гэжээ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд тохируулж олгосон агнах зөвшөөрлийн тоонд нийцүүлэн агнуурын зөвшөөрөл олгох эрхийг сум эдэлдэг.






“Зөрчлийн тухай” хууль болон Эрүүгийн хуульд газар нутагт суурилан хийдэг гэмт үйлдэл, тэдгээрт хүлээлгэх хариуцлагын талаар заажээ. Тухайлбал, “Зөрчлийн тухай” хуульд 1) Монгол Улсад хилийн бүсэд мөрдөгдөх ан агнуурын журмыг зөрчих 2) Агнуур хийхийг зөвшөөрсөн газраас бусад газарт ан хийх зэрэг үйлдлүүд оржээ.

Хилийн бүсэд ан хийсэн тохиолдолд ноогдуулах шийтгэл нь хувь хүнд 50 нэгжтэй (50,000 төгрөг) тэнцэх хэмжээний торгууль ноогдуулах, хэрэв тухай гэмт үйлдлийг хуулийн этгээд үйлдсэн бол энэхүү хэмжээг арав дахин нэмэгдүүлэн 500 нэгжтэй (500,000 төгрөг) тэнцэх торгууль ноогдуулахаар заажээ. Зөвшөөрсөн газраас бусад газарт ан хийх тохиолдолд ноогдуулах торгууль нь 6 дахин өндөр буюу хувь хүнд 150 нэгж, аж ахуйн нэгжид 6 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгуультай байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт буудсан, хавхдах болон бусад аргаар аргаар агнасан бол Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн дагуу 5,400 - 27,000 нэгжтэй (5,4 - 27 сая төгрөг) тэнцэх хэмжээний торгууль ноогдуулна. Үүнтэй ижил үйлдэл нь мөн 1- 5 жил баривчлах, эсвэл 1-5 жил хорих хүртэл ялтай. Түүнчлэн тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх хориотойн дээр ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэхийг хориглоно. Байгалийн нөөц газарт мөн амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэхийг тус тус хориглодог. Амьтныг тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүй агнах нь гэмт хэрэг хэмээн Эрүүгийн хуулийн 24.5.1-д заажээ.

ТА ЗЭРЛЭГ АМЬТАН АГНАХ ХОРИОТОЙ ХУГАЦААГ МЭДЭХ ҮҮ?



“Амьтны тухай” хуулийн 9 дүгээр зүйлд агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацааг тодорхой заасан байдаг. Ийнхүү агнуурын хориотой хугацаа тогтоож өгөх нь тухайн зүйл амьтны үржлийн үед эмзэг байх үед нь агнуурт өртүүлэхгүй байж өсөж үржиж тоо толгой нь тогтвортой хадгалагдаж байх нөхцөлийг хангах зорилготой юм. Амьтныг агнах хориотой улиралд агнавал “Зөрчлийн тухай” хуулийн 7.6.4- р зүйлийн дагуу зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



■ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Амьтдыг агнахыг хориглох хугацаа



Амьтдыг эрхийн бичиг, тусгай зөвшөөрөлтэйгөөр агнах хугацаа



Амьтдыг амьдаар барихыг хориглох хугацаа



АМЬТНЫ НЭР ТӨРӨЛ	1-Р САР	2-Р САР	3-Р САР	4-Р САР	5-Р САР	6-Р САР	7-Р САР	8-Р САР	9-Р САР	10-Р САР	11-Р САР	12-Р САР
УГАЛЗ						30-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ				01-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН		
АРГАЛЬ ХОНЬ								20-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ		20-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		
ТЭХ							14-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ			16-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		
ХАР СҮҮЛТ ЗЭЭРИЙН ООНО								31-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ			01-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН	
ХАР СҮҮЛГИЙ ЗЭЭР							15-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ			15-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		
ХАЛИУН БУГА						30-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ			30-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН			
ХАЛИУН БУГА						20-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ				20-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		
БОР ГӨРӨӨС ЦАГААН ЗЭЭР ЗЭРЛЭГ ГАХАЙ								31-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ				1-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН
УРТ СҮҮЛТ ЗУРАМ, ТАРВАГА								20-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ		16-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		
ОЙН БУЛГА, ХАДНЫ СУУСАР, ЭЛБЭНХ, НОХОЙ ЗЭЭХ, ОЙН СОЛОНГО, УСНЫ БУЛГА, ӨМХИЙ ХҮРЭН, ХОТНЫ ҮЕН, ЦАГААН ҮЕН, ШИЛҮҮС, ШАР ҮНЭГ, ХЯРС ҮНЭГ, МАНУУЛ МИЙ, БАРААН ХЭРЭМ, ЧАНДАГА ТУУЛАЙ, БОР ТУУЛАЙ		11-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН									20-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ	
ЗААРТ ХАРХ		1-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН									15-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ	
ХАЛЗДАЙ ДОРГО	31-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ										15-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН	
ШИВЭР ХӨТҮҮ, ДАГУУР ЯТУУ, ЭРЭЭНХАВИРГА ХАХИЛАГ, ГОВИЙН НОГТРУУ, ХАР ХУР, ЭГЭЛ СОЙР			15-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН							31-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ		

ГАЛУУ, НУТАС БОЛОН УС, НАМГИЙН БУСАД АГНУУРЫН ШУВУУ			31-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ	20-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН				31-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ		20-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		
ИДЛЭГ ШОНХОР ШУВУУ						20-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ					15-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН	
ЦАРМЫН БҮРТЭД										01-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ	01-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН	
ДАРХАДЫН ЦАГААН ЗАГАС								01-НИЙ ӨДРӨӨС		20-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ		
БУЙР НУУРЫН ЗАГАС					15-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН			1-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ				
ОМОЛЬ ЗАГАС								30-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		30-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ		
ЗАРАМ ЗАГАС	30-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ								05-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН			
АЛТАЙН СУТАС						15-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		31-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ				
БУСАД ЗАГАС				01-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН		15-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ						
ТУЛ ЗАГАС						15-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ				30-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН		



© Д. Лхагвасүрэн

АМЬТАН АГНАХ ХОРИОТОЙ АРГА ХЭРЭГСЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



“Зөрчлийн тухай” хуулиар агнуурын амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгслийг зохицуулсан байдаг. Үүнд химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах, агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих, тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах, агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашлага, гувчуур хэрэглэх, ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх, ан агнах зориулалтын бус буу, сумаар агнах болон гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлахыг хориглодог.



ЯМАР АМЬТДЫГ АГНАХЫГ ХОРИГЛОСОН БЭ?



© Д. Лхагвасүрэн

2012 оны “Амьтны тухай” хууль нь амьтны зүйлийг харгалзсан аргачлалыг ашиглаж, зэрлэг амьтны зүйлийн ангиллыг гаргасан. Үүнд: 1) Нэн ховор, 3) Агнуурын амьтан 2) Ховорхэмээн ялгаж, эдгээр зэрэглэлд үндэслэн агнуурыг хязгаарлах, эсвэл зөвшөөрөл олгодог. Нэн ховор амьтны жагсаалтыг шууд хуулиар зааж, хамгийн өндөр түвшинд хамгаалдаг бөгөөд зөвхөн судалгааны зорилгоор ашиглах боломжтой. Ховор амьтны жагсаалт болон хамаарах агнуурын журмыг тусад нь Засгийн газраас тогтоодог. Агнуурын амьтны зохицуулалтыг зөвхөн “Амьтны тухай” хуульд зааж агнуурын улирлыг тогтоодог ч амьтны тоо хэмжээг заадаггүй. Эрүүгийн хуулиар Нэн ховор

амьтны жагсаалтад орсон бүх амьтны агнуур болон худалдаанд илүү өндөр торгууль, хатуу шийтгэл ноогдуулдаг. Ховор зүйлийн жагсаалтад орсон амьтны хувьд, тусгайлан заасан эрүүгийн гэмт хэргийн заалт нь агнах, хавхдах, худалдан авах, борлуулах, боловсруулах, тээвэрлэх болон экспортлох үйлдлүүд багтана. “Нэн ховор” болон “Ховор” зүйлийн хувьд хүлээх хариуцлага нь бараг ижил бөгөөд ялгаатай заалт нь “хадгалах”, “амьдрах орчныг алдагдуулах” дээр байдаг.

“Амьтны тухай” хуулийн дагуу нэн ховор амьтныг агнахын тулд Засгийн газраас заавал зөвшөөрөл авахын зэрэгцээ тусгай зориулалтаар агнах ангийн квотыг мөн Засгийн газар

тогтоодог. Одоогоор тус жагсаалтад хэсэгчилсэн байдлаар агнах, 31 зүйл нэн ховор, 76 зүйл ховор худалдаалах хориг хязгаарлалттай амьтан бүртгэгдээд байна. Нийт байна. 107 зүйлийн амьтан бүрэн, эсвэл

“Нэн ховор амьтан” гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг хэлнэ.

“Ховор амьтан” гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг хэлнэ.

Монгол Улсын хуулиар хамгаалсан амьтад

Нэн ховор амьтад

1. Мазаалай баавгай	<i>Ursus arctos gobiensis</i> - CITES I
2. Хавтгай тэмээ	<i>Camelus bactrianus ferus</i>
3. Тахь адуу	<i>Equus ferus przewalskii</i> - CITES I
4. Ойн буган цаа	<i>Rangifer tarandus</i>
5. Цоохор ирвэс	<i>Uncia uncia</i> - CITES I
6. Баданга хүдэр	<i>Moschus moschiferus</i> - CITES II
7. Молцог хандгай	<i>Alces alces</i>
8. Татаар бөхөн	<i>Saiga tatarica</i>
9. Голын халиу	<i>Lutra lutra</i> - CITES I
10. Азийн минж	<i>Castor fiber</i>
11. Ойн унтаахай	<i>Dryomys nitedula</i>
12. Зүүн гарын даахай	<i>Stylodipus sungorus</i>
13. Борцгор хотон	<i>Pelicanus crispus</i> - CITES I
14. Хургач бор	<i>Paradoxornis heudei</i>
15. Цагаан тогоруу	<i>Grus leucogeranus</i> - CITES I
16. Хар мөрний хилэм	<i>Acipenser schrenckii</i> - CITES II
17. Шаргал үхэрдэй	<i>Tinca tinca</i>
18. Цөөвөр чоно	<i>Cuon alpinus</i> - CITES I
19. Шивэр молцог хандгай	<i>Alces alces pfizenmayeri</i>
20. Дорнын молцог хандгай	<i>Alces alces cameloides</i>
21. Соргог бөхөн	<i>Saiga tatarica</i>
22. Монгол бөхөн	<i>Saiga borealis</i> - CITES II
23. Алтайн чацуулин	<i>Talpa altaica</i>
24. Гозоорой зурам	<i>Citellus alaschanicus</i>
25. Сухайн чичүүл	<i>Meriones tamariscinus</i>
26. Давжаа алагдаага	<i>Allactaga elater</i>
27. Цагаантолгойт ямаан сүүл	<i>Oxyura leucocephala</i> - CITES II
28. Могойч загалай	<i>Circaetus gallicus</i> - CITES II

29. Бор бүргэд
30. Усны нөмрөг бүргэд
31. Реликт цахлай

Aguilla clanga -CITES II
Haliaeetus leucoryphus - CITES I
Larus relictus - CITES I

Ховор амьтад

1. Дорны сармаахай
2. Ойн булга
3. Говийн шилүүс
4. Суусар булга
5. Эрээн хүрнэ
6. Хүрэн баавгай
7. Хулан адуу
8. Зэгсний зэрлэг гахай
9. Халиун буга
10. Хар сүүлтий
11. Аргаль хонь
12. Янгир ямаа
13. Элсний тажигдаахай
14. Соотон алагдаахай
15. Одой галуу
16. Байгалийн нугас
17. Ундар шумбуур
18. Хан бүргэд
19. Ооч ёл
20. Азийн цууцил
21. Монгол хулан жороо
22. Хонин тоодог
23. Усны бух
24. Бичил одой бух
25. Зээрд дэглий
26. Манхин галуу
27. Гэээгт нугас
28. Хуруут хун
29. Хархираа тогоруу
30. Цагаан сүүлт нөмрөг
31. Алтайн хойлог
32. Зэрлэг гургуул
33. Загийн бор
34. Ойн шийхнүүхэй
35. Шагшуургын шатан сүүлт
36. Өгөөлэй шулганаа
37. Наран хөмрөг
38. Шар элэгт хөмрөг
39. Говийн нүцгэн хуруут гүрвэл
40. Тойрмын хонин гүрвэл
41. Толбот могой гүрвэл
42. Тэмээн сүүл могой
43. Нарийн могой

Vespertilio superans
Martes zibellina
Lynx lynx isabellina
Martes foina
Vormela peregusna
Ursus arctos - CITES II
Equus hemionus hemionus
Sus scrofa nigripes
Cervus elaphus
Gazella subgutturosa
Ovis ammon - CITES II
Capra sibirica
Sabbingotus kozlovi
Euchoreutes naso
Anser erythropus
Anas formosa - CITES II
Aythya nyroca
Aquila heliaca - CITES I
Gypaetus barbatus CITES II
Limnodromus semipalmotus
Podoces hemdersoni
Otus tarda - CITES II
Botaurus stellaris
Ixobrychus minutus
Ardea purpurea
Anser albifrons
Anas Falcata
Cygnus olor
Grus grus - CITES II
Haliaeetus albicilla - CITES I
Tetraogallus altaicus
Phasianus colchicus
Passer ammodendri
Anthus trivialis
Locustella luscinioides
Saxicola insignis
Emberiza yessoensis
Emberiza aureola
Cyrtapodion elongatus
Phrynosephalus helioscopus
Eremias arguta potanini
Eryx tataricus - CITES II
Coluber spinalis

44. Эгэл загалмайт могой	<i>Vipera berus</i>
45. Шивэр гүлмэр	<i>Salamandrella keyserlingii</i>
46. Ногоон бах	<i>Bufo danatensis</i>
47. Модны мэлхий	<i>Hyla japonica</i>
48. Дорнодын мэлхий	<i>Rana chensinensis</i>
49. Тул	<i>Hucho taimen</i>
50. Номхон далайн могор	<i>Lampetra japonica</i>
51. Төст царцаа	<i>Eclipophleps similis</i>
52. Эмэлжановын голио	<i>Eulithoxenus emeljanovi</i>
53. Дамнуурга цэнхэр соно	<i>Aeshna juncea mongolica</i>
54. Шүтээн цох	<i>Scarabaeus typhoon</i>
55. Дорнын заар эвэрт цох	<i>Aromia moschata orientalis</i>
56. Аполлон эрвээхэй	<i>Parnassius apollo</i>
57. Эверсманны дэвүүр	<i>Parnassius eversmanni</i>
58. Штуббендорфын дэвүүр	<i>Parnassius stubbendorfi</i>
59. Фэб дэвүүр	<i>Parnassius phoebus</i>
60. Зүүн сибирийн дэвүүр	<i>Parnassius tenedius</i>
61. Махаон дэвүүр	<i>Parnassius mashaon</i>
62. Одон бүгэг эрвээхэй	<i>Macroglossum stellatarum</i>
63. Инжирийн шумбуур	<i>Deilephila elpenor</i>
64. Голт борын шумбуур	<i>Sphinx ligustri</i>
65. Бэр цэцэгч шумбуур	<i>Hemaris tityus</i>
66. Хөвдний үхэр хэдгэнэ	<i>Bombus muscorum</i>
67. Модестус үхэр хэдгэнэ	<i>Bombus modestus</i>
68. Спорадикус үхэр хэдгэнэ	<i>Bombus sporadicus</i>
69. Байгалийн үхэр хэдгэнэ	<i>Bombus subbaicalensis</i>
70. Ихэр ирлэг ялаа	<i>Satanas gigas</i>
71. Хар мөрний хавч	<i>Leander modestus</i>
72. Голын хавч	<i>Cambaroides dauricus</i>
73. Дагуурын сувдан хясаа	<i>Dahurinaia dahurica</i>
74. Дэлт танан хясаа	<i>Cristaria plicata</i>
75. Сэлэнгийн танан хясаа	<i>Anodonta sedakovi</i>
76. Монгол танан хясаа	<i>Middendorffinaia mongolica</i>

Ховор амьтан: торгуулийн доод хэмжээ нь 5,400 нэгж (5.4 сая төгрөг), дээд хэмжээ нь 27,000 нэгж (27 сая төгрөг), мөн 1-5 жил хугацаагаар баривчлах, 1-5 жил хорих ял ноогдуулахаар заажээ.

Нэн ховор амьтан: торгуулийн доод хэмжээ 10,000 нэгж (10 сая төгрөг), дээд хэмжээ нь 40,000 нэгж (40 сая төгрөг) эсвэл 2-8 жил хүртэл хорих ял ноогдуулна.

МОНГОЛ УЛС НЭГДЭН ОРСОН САЙТИС-Н КОНВЕНЦЫГ ЯАГААД БИД МЭДЭХ ЁСТОЙ ВЭ?



© Д. Лхагвасүрэн

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (САЙТИС *англ.* CITES) нь зэрлэг амьтан, ургамлын аливаа зүйл олон улсад хэт их хэмжээгээр худалдаалагдаж, устгах аюулд орохоос хамгаалах, худалдааг олон улсын хяналт зохицуулалттай хийх зорилготой. Тиймээс энэхүү конвенцод устгах аюулд орсон хамгаалах шаардлагатай зэрлэг амьтан ургамлыг гурван ангилалд хувааж олон улсын худалдааны ялгаатай хяналт тогтоодог. **Нэгдүгээр хавсралтад** устгах

аюулд орсон, худалдаалах үйл ажиллагаанд өртөгдөж байгаа буюу цаашид өртөгдөж болох бүх амьтад багтана. Эдгээр зүйлийн төлөөлөх биетийг худалдаалахыг зөвхөн онцгой нөхцөлд зөвшөөрөх ба худалдаалах үйл ажиллагааг тэдгээрийн оршин тогтнох байдалд аюул занал учруулахгүйгээр хатуу хяналт, зохицуулалтын дор явуулна. **Хоёрдугаар хавсралтад** хэдийгээр эдүгээ устгах аюул заналхийлээгүй боловч цаашид оршин тогтноход харшлахаар ашиглалт явуулахгүй байх, тэдгээрийн төлөөлөх биетийн худалдааг хатуу хяналт зохицуулалттай хийх

шаардлагатай бүх амьтан орно. Гуравдугаар хавсралтад аливаа талд ашиглуулахгүй байх, ашиглалтыг хязгаарлахад үндэсний хуулийн хүрээнд зохицуулсан, тэдгээрийг худалдаалахыг хянахад бусад улс орнуудтай хамтарч ажиллах шаардлагатай байгаа бүх амьтан багтана.

Манай улсаас САЙТИС-ын конвенцын I хавсралтад орсон хөхтөн амьтад бол цоохор ирвэс, голын халиу, мазаалай баавгай, тахь адуу, хулан адуу юм. Эдгээр амьтад устаж үгүй болох аюулын ирмэг дээр байгаа, худалдааны хувьд хатуу зохицуулалттай, зөвхөн судалгаа шинжилгээ гэх мэт онцгой тохиолдолд зөвшөөрөл өгдөг.

Конвенцын II хавсралтад багтсан хөхтөн амьтад бол саарал чоно, хүрэн баавгай, аргаль хонь, монгол бөхөн, баданга хүдэр юм. Эдгээр амьтдын худалдааг зохицуулж хянахгүй бол мөхлийн ирмэгт тулж болзошгүй амьтад тул заавал зөвшөөрөл авч хил нэвтрүүлнэ. Монгол Улсаас 14 зүйл хөхтөн амьтан САЙТИС I ба II хавсралтад орсон бол 72 зүйл шувууд, 1 зүйл мөлхөгч 2 зүйл загас,

1 зүйл шавж 8 зүйл ургамал тус конвенцын хүрээнд хамгаалагджээ. САЙТИС-ын конвенцын хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, реэкспортлох буюу далай тэнгисээс олборлон оруулах гэрчилгээг улсын хил дээр гаалийн байцаагчид шалгуулж нэвтэрнэ.

Манай улсын “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай” хуульд зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага конвенцын хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, реэкспортлох буюу далай тэнгисээс олборлон оруулах гэрчилгээ авах хүсэлтээ конвенцын Удирдан Зохицуулах Зөвлөлд гаргана. Тус зөвлөл уг хүсэлтийг хүлээн авч зөвшөөрөл, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ. Зөвшөөрөл, гэрчилгээ олгох журам болон гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Олон улсын хэмжээнд хамгаалагдсан Монголын зэрлэг амьтад

#	САЙТИС (CITES) I хавсралт		САЙТИС (CITES) II хавсралт
Хөхтөн			
1	Цоохор ирвэс (<i>Uncia uncia</i>)	1	Шилүүс мий (<i>Lynx lynx Linnaeus</i>)
2	Голын халиу (<i>Lutra lutra Linnaeus</i>)	2	Цоохондой мий (<i>Felis silvestris Schreber</i>)
3	Мазаалай баавгай (<i>Ursus arctos isabellinus Horsfield</i>)	3	Мануул мий (<i>Felis manual Pallas</i>)
4	Тахь адуу (<i>Equus ferus przewalskii Groves</i>)	4	Саарал чоно (<i>Canis lupus Linnaeus</i>)
5	Хулан адуу (<i>Equus hemionus Pallas</i>)	5	Шарнад цөөвөр (<i>Cuon alpinus Pallas</i>)
		6	Хүрэн баавгай (<i>Ursus arctos Linnaeus</i>)
		7	Аргаль хонь (<i>Ovis ammon Linnaeus</i>)

		8	Монгол бөхөн (<i>Saiga borealis</i> Tschersky)
		9	Баданга хүдэр (<i>Moschus moschiferus</i> Linnaeus)
Шувуу			
1	Борцгор хотон (<i>Pelecanus crispus</i>)	1	Халбаган хошуут (<i>Platylea leucorodia</i>)
2	Дорнын өрөвтас (<i>Ciconia boyciana</i>)	2	Хар өрөвтас (<i>Ciconia nigra</i>)
3	Хан бүргэд (<i>Aquila heliaca</i>)	3	Ягаан нал (<i>Phoenicopiterus roseus</i>)
4	Цагаансүүлт нөмрөг бүргэд (<i>Haliaeetus albicilla</i>)	4	Байгалийн нугас (<i>Anas formosa</i>)
5	Усны нөмрөг бүргэд (<i>Haliaeetus leucorhynchus</i>)	5	Цагаантолгойт ямаан сүүл (<i>Oxyura leucocephala</i>)
6	Цагаан шонхор (<i>Falco rusticolus</i>)	6	Загасч явлаг (<i>Pandion haliaetus</i>)
7	Эгэл шонхор (<i>Falco peregrines</i>)	7	Балч гоорбис (<i>Pernis apivorus</i>)
8	Шилийн шонхор (<i>Falco peregrinoides</i>)	8	Согсоот гоорбис (<i>Pernis ptilorhynchus</i>)
9	Алаг тогоруу (<i>Grus japonensis</i>)	9	Сохор элээ (<i>Milvus migrans</i>)
10	Цагаан тогоруу (<i>Grus leucogeranus</i>)	10	Саарал хүлд (<i>Circus cyaneus</i>)
11	Цэн тогоруу (<i>Grus vipio</i>)	11	Хээрийн хүлд (<i>Circus macrourus</i>)
12	Хар тогоруу (<i>Grus monacha</i>)	12	Нугын хүлд (<i>Circus pygargus</i>)
13	Жороо тоодог (<i>Chlamydotis macqueenii</i>)	13	Алаг хүлд (<i>Circus melanoleucus</i>)
14	Реликт цахлай (<i>Larus relictus</i>)	14	Намгийн хүлд (<i>Circus aeruginosus</i>)
		15	Дорнын хүлд (<i>Circus spilonotus</i>)
		16	Үлэг харцага (<i>Accipiter gentilis</i>)
		17	Морин харцага (<i>Accipiter nisus</i>)
		18	Үүрсээ харцага (<i>Accipiter badius</i>)
		19	Шунгаац харцага (<i>Accipiter gularis</i>)
		20	Тарлан сар (<i>Buteo lagopus</i>)
		21	Шилийн сар (<i>Buteo hemilasius</i>)
		22	Талын сар (<i>Buteo rufinus</i>)
		23	Ойн сар (<i>Buteo buteo</i>)
		24	Саржуу харцгай (<i>Butastur indicus</i>)
		25	Могойч загалай (<i>Circus gallicus</i>)
		26	Уулын согсоот бүргэд (<i>Spizaetus nipalensis</i>)
		27	Бахим бүргэд (<i>Hieraaetus pennatus</i>)
		28	Харсун бүргэд (<i>Hieraaetus fasciatus</i>)
		29	Тарважи бүргэд (<i>Aquila nipalensis</i>)
		30	Бор бүргэд (<i>Aquila clanga</i>)
		31	Цармын бүргэд (<i>Aquila chrysaetos</i>)
		32	Ооч ёл (<i>Gypaetus barbatus</i>)
		33	Дэлт ёлон (<i>Neophron percnopterus</i>)
		34	Нөмрөг тас (<i>Aegypius monachus</i>)
		35	Ухаа хажир (<i>Gyps fulvus</i>)
		36	Хималайн хажир (<i>Gyps himalayensis</i>)
		37	Идлэг шонхор (<i>Falco cherrug</i>)
		38	Шууман шонхор (<i>Falco subbuteo</i>)
		39	Хайргууна шонхор (<i>Falco columbarius</i>)
		40	Түрамтай шонхор (<i>Falco vespertinus</i>)

	41	Амарын шонхор (<i>Falco amurensis</i>)
	42	Зээрд шонхор (<i>Falco naunmanni</i>)
	43	Начин шонхор (<i>Falco tinnunculus</i>)
	44	Хархираа тогоруу (<i>Grus grus</i>)
	45	Өвөгт тогоруу (<i>Anthropoides virgo</i>)
	46	Хонин тоодог (<i>Otis tarda</i>)
	47	Цагаан уульж (<i>Nyctea scandiaca</i>)
	48	Эгэл шаршувуу (<i>Bubo bubo</i>)
	49	Соотон гуйванга (<i>Asio otus</i>)
	50	Хулгар гуйванга (<i>Asio flammeus</i>)
	51	Ердийн орволго (<i>Otus scops</i>)
	52	Ойн орволго (<i>Otus sunia</i>)
	53	Савагт ариан (<i>Aegolius funereus</i>)
	54	Хотны бүгээхэй (<i>Athene noctua</i>)
	55	Буслаг сүлиг (<i>Glaucidium passerinum</i>)
	56	Харсуун бэгбаатар (<i>Serhia ulula</i>)
	57	Хувь ууль (<i>Strix uralensis</i>)
	58	Угалзан ууль (<i>Strix nebulosa</i>)
Мөлхөгч		
	1	Тэмээн сүүл могой (<i>Eryx tataricus</i>)
Загас		
	1	Шивэр хилэм (<i>Acipenser baeri</i>)
	2	Амар мөрний хилэм (<i>Acipenser schrenckii</i>)
Шавьж		
	1	Аполлон (<i>Parnassius apollo</i>)

Нэн ховор эсвэл Ховор амьтны жагсаалтад багтаагүй ч САЙТИС-ын жагсаалтад багтсан амьтныг хууль бусаар хил давуулсан бол тусдаа шийтгэл ноогдуулдаг. Торгууль нь 500 нэгжээс (хувь хүнд), 5,000 нэгж хүртэл (хуулийн этгээд) байхаар заасан нь 500,000- 5 сая төгрөгтэй тэнцэнэ.

Зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох буюу импортлох зөвшөөрлийн гэрчилгээ



CONVENTION ON
INTERNATIONAL TRADE IN
ENDANGERED SPECIES OF
WILD FAUNA AND FLORA

ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН
ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН
ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИ

PERMIT / CERTIFICATE №

☐ EXPORT
☐ RE-EXPORT
☐ IMPORT
☐ OTHER

Original

2. Valid until
Хуучиралт бүтэх өдөр

3. Importer (name and address) Хамтлогчдын нэр, хаяг		4. Exporter (name and address, country) Эхлүүлэгчийн нэр, хаяг, улс	
3a. Country of importer Хамтлогчийн улс		Signature of the applicant Хуучиралтын үзүүлэгч	
5. Special conditions Тусгай нөхцөл		6. Name, address, national seal/stamp and country of Management Authority  MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM Government Building #2 United Nations Street 5/2, Ulaanbaatar-15160, MONGOLIA Tel: 976-51-261726 Fax: 976-11-321401 E-mail: mne@mongol.net	
5a. Purpose of the transaction (see reverse) Худалдсаны зориулалт		5b. Security stamp/lie Машины дүрэл	
7a. SCIENTIFIC NAME (genus and species) AND COMMON NAME OF ANIMAL OR PLANT (Scientific name in Latin, followed by the common name)	7b. Description of specimens, including identifying marks or numbers (specimens if live) (Indicate the number of specimens, their sex, age, etc.)	7c. Appendix No. and source Хавсрууллын дүрэл, эх үүсвэр	7d. Quantity (including unit) Тус бүрний тоо (нэгж)
7e. Total exported (Indicate the total quantity)	7f. Total imported (Indicate the total quantity)		
12. Country of origin * (Indicate the country of origin)	Permit No. (Indicate the permit number)	Date (On day, month, year)	12a. Country of last export (Indicate the country of last export)
12b. Country of last import (Indicate the country of last import)	12c. Number of the operation ** or date of acquisition *** (Indicate the number of the operation or the date of acquisition)	12d. Date of acquisition *** (Indicate the date of acquisition)	
* Country in which the specimens were taken from the wild, bred in captivity or artificially propagated (only in case of re-export) (Indicate the country of origin of the specimens)			
** Only for specimens of Appendix I species and artificially propagated for commercial purposes (Indicate the number of the operation)			
*** For pre-Convention specimens (Indicate the date of acquisition)			
13. THIS PERMIT IS ISSUED BY: Бэлгэдсэнээр гаргасныг үндэслэн  Place Country name Security stamp, signature and official seal Бэлгэдсэнээр гаргах, гарын үсэг, тэмдэг Date On day, month, year			
14. EXPORT ENDORSEMENT: Тус, хуучиралтын дүрэл (Indicate the endorsement)		15. Bill of Lading/Air Waybill Number Авиацийн тээврийн гэрчилгээний дүрэл	
Block Group	Quantity Total number	Part of Export Эхлүүлэгчийн хэсэг	
A	B	Date On day, month, year	Signature Гарын үсэг
C	D	Official stamp and the Тэмдэг	

ХУУЛИЙН ХҮРЭЭНД АГНУУРЫН НӨӨЦИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?



40

Монгол орны ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй элбэг агнуурын амьтдыг “Амьтны тухай” хуулийн дагуу иргэд зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болно. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь агнуурын амьтны тархац нутагт ан амьтныг агнах, барих агнуурын бүс нутгийг ан агнуурын менежментийн төлөвлөгөөг үндэслэн тогтооно. Ахуйн зориулалтаар ан агнахын тулд тухайн иргэн эхлээд аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас (Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар) анчны үнэмлэх авах ёстой бөгөөд галт зэвсгийн тухай хуулийн дагуу иргэний

Амьтан агнах, барих зөвшөөрлийн загварууд



зориулалтаар ан агнах зорилгоор ашиглах галт зэвсэг (автоматаар, эсхүл өөрөө цэнэглэгдэх боломжгүй, хүхээгт нь арав, түүнээс цөөн сум орох багтаамжтай, үйлдвэрийн хийцийг нь өөрчлөөгүй галт зэвсэг)-ийг оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад бүртгүүлж галт зэвсгийн гэрчилгээ авна. Агнуурын амьтны амьдрал, биологи, агнуурын уламжлалт соёлын талаар

мэдлэгтэй, ан агнах, барих арга зүй эзэмшсэн, түүнтэй холбогдсон шалгуурыг хангасан иргэнд анчны үнэмлэх олгоно. Анчны үнэмлэхтэй буу эзэмших гэрчилгээтэй иргэн тухайн сумын Засаг даргад ахуйн зориулалтаар ан хийх хүсэлт гаргаж амьтан агнах, барих төлбөр, зөвшөөрлийн хураамжийг төлнө. Үүний дараа ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих эрхийн бичиг олгоно. Эрхийн бичигт иргэний овог, эцгийн нэр, нэр, агнах барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах барих хугацаа, газар, төлбөр хураамжийн хэмжээг нарийвчлан заана. Ийнхүү зөвшөөрлийн дагуу ан хийх агнуурын бүс нутгаа сумын байгаль хамгаалагчаар заалгаж ан хийнэ. Энэхүү эрхийг бичигт тодорхой хугацаа заасан байх ба тарвага, загасыг 3 хүртэл хоног,



бусад агнуурын амьтныг 5 хүртэл хоногт багтаан агнаж барина. Түүнчлэн тоо ширхгийн тухайд туурайтан амьтан 1, тарвага 5, бусад үслэг ан 1, хөтүү, ятуу, ногтруу шувуу тус бүр 10, бусад агнуурын шувуу 5, бусад агнуурын загас 10 ширхгээс илүүгүй байна. Агнасны дараа тухайн сумын байгаль хамгаалагчаас гарал үүслийн тодорхойлолт бичиг авна. Иргэн, хуулийн этгээд тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч агнуурын амьтныг агнаж барина. Тусгай зориулалт гэдэгт агнуурын амьтныг эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар, иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр болон нутаг дэвсгэрт агнуурын амьтны сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор агнах барих үйл ажиллагааг ойлгоно. Эдгээр зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно. ЗАСГИЙН ГАЗРЫН 2013 ОНЫ 93 ДУГААР ТОГТООЛЫН ХОЁРДУГААР

ХАВСРАЛТААР ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журмыг баталсан байна.

Хуулийн этгээд үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тухайн сумын Засаг даргатай гэрээ байгуулна. Сумын Засаг дарга хуулийн этгээдтэй үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээ байгуулахдаа сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрт үндэслэж тухайн хуулийн этгээд мэргэжлийн боловсон хүчин, анчидтай байгаа эсэхийг магадалж агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхтай байх шалгуурыг хангасан эсэхийг харгалзаж гэрээ байгуулна. Заасан үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээнд агнах, барих агнуурын амьтны нэр, тоо хэмжээ, агнах хугацаа, газар, бэлтгэх түүхий эдийн нэр төрөл, тоо, төлбөр, хураамжийн хэмжээг нарийн тусгана.



БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ҮҮРЭГ ЮУ ВЭ?

ХҮН БҮР БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ
БАЙЖ ЗЭРЛЭГ АМЬТДАА ХАЙРЛАН
ХАМГААЛЦГААЯ!

102



Иргэний хувьд юу хийх вэ?

- Зэрлэг амьтны гаралтай түүхий эд хэрэглэхгүй байх
- Эрх зүйн наад захын мэдлэгтэй байх
- Ховор, хамгаалагдсан амьтдыг таньж мэддэг байх
- Үр хүүхдүүддээ сайн үлгэр үзүүлэх, сургах
- Хууль хяналтын байгууллагад иргэний үүргээ биелүүлж мэдээлэл өгөх
- Гэмт хэрэг зөрчилд холбогдохоос болгоомжилж сэрэмжтэй байх
- Оршин суугаа нутагтаа байгаль хамгаалах нөхөрлөл байгуулж, байгаль хамгааллын ажил зохион байгуулахад идэвхтэй оролцох

Мэдээлэл өгөх шугам юу вэ?


Хууль бус агнуурын талаар бодит мэдээлэл өгсөн тохиолдолд, зөрчилд ноогдуулсан торгуулийн 15%-тэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал авч болдог. Цагдаагийн байгууллага зэрлэг амьтны хууль бус худалдааны талаар мэдээлэл авах 102 нэгдсэн дугаартай байнгын утас ажиллуулж, мэдээлэгчдээс тодорхой сэжүүрийг шууд хүлээн авдаг. Та өөрийн амьдарч буй нутгаа хамгаалах, үр хүүхдийнхээ ирээдүйн төлөө аливаа хууль бус үйл ажиллагаатай өөрийн хүч чадал боломжоор тэмцэж, байгаль хамгаалалд идэвхтэй оролцох нь буянтай сайн үйлс юм.

ЗЭРЛЭГ АМЬТАН УРГАМЛЫГ ХЭРХЭН ТАНЬЖ ТОДОРХОЙЛОХ ВЭ? - ГАР УТАСНЫ АППЛИКЕЙШН “СОРГОГ”

Амьтан ургамлын зүйлүүдийг зүй бусаар ашиглах, хууль бусаар агнах, түүж бэлтгэх, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг худалдаалах гэмт хэрэг нь Монгол Улс төдийгүй дэлхий дахинд тулгамдсан асуудал болж байна. Иймд зэрлэг амьтан, ургамлын хууль бус агнуур, худалдааг бууруулах, таслан зогсооход олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус ажилтнуудад туслах зорилгоор гар утасны Соргог аппликейшнийг Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн газар бүтээсэн. Тус аппликейшнд хууль бус агнуур, худалдаанд ихээхэн өртөж буй амьтан, ургамлын мэдээллийг оруулсан. Ялангуяа, тэдгээр амьтдыг ялган таних шинж, тархалт, амьдрах орчин, тоо толгой, ховордлын шалтгаан, эд, эрхтэн, бүтээгдэхүүн, тэдгээрийн хэрэглээ, хууль эрх зүйн зохицуулалтын талаар гол мэдээлэл орсон. Тухайлбал хууль бус агнуур болон худалдаанд ихээр өртөж, тоо толгой нь цөөрч, ховордож буй 77 зүйл амьтан ба 21 зүйл ургамлын амьдрах орчин, тархалт, ховордлын үнэлгээ, хууль эрх зүй орчин, худалддаг эд, эрхтний талаарх мэдээ, баримтыг үзэж болно. Хэрэглэгчдийн санал шүүмжийг



харгалзан аппликейшнийг 2020 онд шинэчилсэн. Үүнд, зэрлэг амьтан ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах САЙТИС-ийн конвенцод Монгол Улсаас бүртгүүлсэн амьтад, гадаадын гаралтай хууль бус агнуурт өртдөг амьтдын жишээ, төрөл зүйлийн фото зургуудын нэмэн оруулж, хууль тогтоомжийн шинэ заалт, ан агнуурын хориотой улирлын мэдээг шинэчилж, хэрэглэгчдээс мэдээлэл хүлээн авах цэс шинээр нэмсэн болно. Соргог аппликейшн нь хууль бусаар агнасан амьтдын эд, эрхтэн, бүтээгдэхүүнийг иргэд худалдан авч эрсдэлд орохоос сэргийлэх, хууль хяналтын ажилтнуудад эдгээр амьтдыг хялбар таних, тодорхойлоход тус нэмэр болох зорилготой.



Google Play Store
болон
Apple App Store-с
"СОРГОГ" гэж
хайгаад татаж
суулгана уу.



ZSL
LET'S WORK
FOR WILDLIFE

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн
Монгол дахь Төлөөлөгчийн газар,
Монре импекс ХХК-ийн байр, 302 тоот өрөө, Бага тойруу -47,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс. Утас: 7711138

© Д. Лхагвасүрэн

